




“ЭКОНОМИКСИЙН ЦАГААН ТОЛГОЙГ ХЭН САЙН МЭДЭХ ВЭ?”
УЛСЫН XIV ОЛИМПИАД

Хугацаа 60 минут

2018-04-21

1. Дараах дүгнэлтүүдийн аль нь худал вэ?
 - a. Ховор хомс байдал нь боломжит хувилбаруудаас аль нэгийг сонгохыг шаарддаг.
 - b. Ховор хомс байдал гэдэг нь бидний хэрэгцээ бүтээгдэхүүн болон нөөцийн хэмжээнээс бага байхыг илэрхийлдэг.
 - c. Ховор хомс байдал болон хүмүүсийн амьдралын нөхцлөө сайжруулах хүсэл сонирхлоос өрсөлдөөн бий болдог.
 - d. Ховор хомс байдал байхгүй болно гэдэг нь бидний хувьд бүтээгдэхүүн болон үйлчилгээний бүх хэрэгцээ бүрэн хангагдана гэсэн үг.

2. ОВ хэмжээний машиныг үйлдвэрлэж байх үеийн алдагдсан боломжийн өртөг нь



- a. OD хэмжээний эрдэнэ шишийн үйлдвэрлэл
- b. OE хэмжээний эрдэнэ шишийн үйлдвэрлэл
- c. ED хэмжээний эрдэнэ шишийн үйлдвэрлэл
- d. OC хэмжээний машин үйлдвэрлэл

3. Доржийн үйлдвэрлэлийн боломжийн муруй дээрх дараах хувилбаруудыг ашиглан C-ээс B-д шилжихэд нэг нэгж 2-р бүтээгдэхүүнийг хийх үеийн алдагдсан боломжийн зардал нь ямар байхыг тодорхойл.

Хувилбар	A	B	C	D	E
1-р бүтээгдэхүүн	0	20	40	60	80
2-р бүтээгдэхүүн	10	9	7	4	0


- a. 40 нэгж 1-р бүтээгдэхүүн
 - b. 20 нэгж 1-р бүтээгдэхүүн
 - c. 10 нэгж 1-р бүтээгдэхүүн
 - d. 8 нэгж 1-р бүтээгдэхүүн
4. Автомашин дугуйг хийхэд резин хэрэглэдэг. Резиний үнийн өсөлттэй зэрэгцэн автомашины дугуй хийх үйлдвэрлэлийн технологид дэвшил гарчээ. Эдгээр үйл явдлуудын үр дүнд
 - a. Автомашин дугуйн эрэлт өсөх ба түүний нийлүүлэлт нь буурна
 - b. Автомашин дугуйн нийлүүлэлт буурах ба түүний эрэлт нь буурна
 - c. Автомашин дугуйн нийлүүлэлт өсч ба түүний эрэлт нь өөрчлөгдөхгүй
 - d. Зөв хариулт алга 5. Хэрэглэгчдийн тооны өсөлттэй зэрэгцэн тухайн бүтээгдэхүүний үйлдвэрлэлд технологийн дэвшил явагджээ. Зах зээлд ямар өөрчлөлт ажиглагдах вэ?
 - a. Тэнцвэрт үнэ өсөх ба борлуулалтын хэмжээ хэрхэн өөрчлөгдөх нь тодорхойгүй
 - b. Тэнцвэрт үнэ буурах ба борлуулалтын хэмжээ хэрхэн өөрчлөгдөх нь тодорхойгүй
 - c. Тэнцвэрт хэмжээ өсөх ба тэнцвэрт үнэ хэрхэн өөрчлөгдөх нь тодорхойгүй
 - d. Тэнцвэрт үнэ ба борлуулалтын хэмжээ зэрэг өснө
 6. Ямар нөхцөлд ноолууран цамцны зах зээлийн тэнцвэрт үнэ буурах вэ?
 - a. Ноосон цамцны үнийн өсөлт ба ноолуурын үнийн бууралт
 - b. Ноосон цамцны үнийн бууралт ба ноолуурын үнийн бууралт
 - c. Ноосон цамцны үнийн өсөлт ба ноолуурын үнийн өсөлт
 - d. Ноосон цамцны үнийн бууралт ба ноолуурын үнийн өсөлт
 7. Хэрэв шатахууны болон гангийн үнэ өсөж, нийтийн тээвэр улам тохилог бөгөөд хямд болж, машины үйлдвэрийн ажилчдын дундаж цалин нэмэгдсэн бол шинэ машины зах зээлд ямар өөрчлөлт гарах вэ?
 - a. Тэнцвэрт үнэ буурах ба тэнцвэрт хэмжээний өөрчлөлт тодорхойгүй
 - b. Тэнцвэрт үнэ өсөх ба тэнцвэрт хэмжээний өөрчлөлт тодорхойгүй
 - c. Тэнцвэрт хэмжээ буурах ба тэнцвэрт үнийн өөрчлөлт тодорхойгүй
 - d. Тэнцвэрт хэмжээ өсөх ба тэнцвэрт үнийн өөрчлөлт тодорхойгүй
 8. Хэрэв бол уг бүтээгдэхүүний үнийн бууралт нийт орлогыг өсгөнө.
 - a. орлогоос хамаарсан эрэлтийн мэдрэмж 1-ээс их
 - b. тухайн бүтээгдэхүүн нь дорд бүтээгдэхүүн
 - c. тухайн бүтээгдэхүүн нь мэдрэмжгүй эрэлттэй
 - d. тухайн бүтээгдэхүүн нь мэдрэмжтэй эрэлттэй
 9. Эрэлтийн функц $Q_d=8-P$ гэж өгөгджээ. Үнэ 4 төгрөг байх үеийн үнээс хамаарсан эрэлтийн мэдрэмжийг ол
 - a. 0.6
 - b. 0.3
 - c. 2
 - d. 1
 10. Цувдайн орлогоос хамаарсан эрэлтийн мэдрэмж -0.2 гэж үзье. Энэ нь дараах утгыг илэрхийлнэ.
 - a. Цувдайн эрэлт мэдрэмжгүй.
 - b. Цувдайн эрэлт нэгж мэдрэмжтэй.
 - c. Цувдайн үнэ өссөн нь борлуулалтын орлогыг бууруулдаг.
 - d. Цувдай нь дорд бүтээгдэхүүн.
 11. Монополийн бүтээгдэхүүн болон борлуулалтын өнөөгийн түвшинд $MR=3.10$; $MC=2.50$ бол дараахаас аль тохиолдолд ашгийг хамгийн их байлгах вэ?

- a. Зах зээлийн нийлүүлэлтийг хянах
b. Зах зээлийн эрэлтийг хянах
- c. Пүүсийн эрэлтийг хянах
d. Аль нь ч биш.
28. 2000-2010 оны хооронд нэрлэсэн ДНБ 1500 тэрбум төгрөгөөс 4500 тэрбум төгрөг хүртэл өссөн гээ. Харин хэрэглээний үнийн индекс 100-аас 150 болж өссөн бол 2010 оны бодит дотоодын нийт бүтээгдэхүүн хэд байх вэ?
a. 1000 тэрбум төгрөг
b. 2000 тэрбум төгрөг
c. 3000 тэрбум төгрөг
d. 4500 тэрбум төгрөг
29. Нэрлэсэн ДНБ 3%-аар өссөн боловч тухайн хугацааны бодит ДНБ 1%-аар өссөн бол
a. Үнийн түвшин ойролцоогоор 1% аар өссөн
b. Үнийн түвшин ойролцоогоор 2% аар өссөн
c. Үнийн түвшин ойролцоогоор 3% аар өссөн
d. Үнийн түвшин ойролцоогоор 4% аар өссөн
30. Татварын түвшин өндөр хувиар өссөн бол
a. Хувь хүмүүс чөлөөт цагийг эрхэмлэх учир ДНБ буурна
b. Засгийн газрын зардал өсөх тул ДНБ нэмэгдсэн татварын орлогын хэмжээгээр өснө
c. ДНБ-д өөрчлөлт орохгүй
d. Засгийн газрын зардал буурч, хувийн хэрэглээний зардал өснө
31. Дараах үйл ажиллагааны аль нь ДНБ -ийг өсгөхгүй вэ?
a. Талх худалдан авах
b. Байрны түрээсийн төлбөрт 500,000 төгрөг төлөх
c. Гэрээ цэвэрлүүлэхээр үйлчлэгч хөлсөлж авах
d. Найзаасаа 5 сая төгрөгийн хувьцаа худалдан авах
32. Та IBM компанийн 3000 ширхэг хувьцааг нэгж бүрийг нь 10\$-аар худалдан авсан бөгөөд 200\$-ийн шимтгэл төлсөн. Тэгвэл энэхүү гүйлгээгээрээ ДНБ-д ямар хувь нэмэр оруулсан бэ?
a. 0
b. 200\$
c. 30000\$
d. 30200\$
33. Хэрэглээний үнийн индекс 2005 онд 120 байсан ба 2006 онд 150 болсон бол 2005-2006 оны хоорондох инфляцийн түвшин хэд байх вэ?
a. 10%
b. 20%
c. 25%
d. 30%
34. Шахан гаргах нөлөөтэй үед засгийн газрын зарлага 100 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн бол
a. Нийт эрэлт 100 тэрбум төгрөгөөс илүүгээр нэмэгдэнэ
b. Нийт эрэлт 100 тэрбум төгрөгөөс багаар нэмэгдэнэ
c. Нийт нийлүүлэлт 100 тэрбум төгрөгөөс илүүгээр багасна
d. Нийт нийлүүлэлт 100 тэрбум төгрөгөөс багаар багасна
35. Бодит үйлдвэрлэл 50 тэрбум төгрөгөөр багассан. Засгийн газар хямралаас сэргийлж зарлагаа ихэсгэхээр төлөвлөв. Хэрэв шахан гаргах нөлөө үржүүлэгчийн нөлөөний хагастай тэнцдэг ба MPC=0.9 бол засгийн газар зарлагаа ямар хэмжээгээр өөрчлөх вэ?
a. 10 тэрбум төгрөгөөр ихэсгэнэ
b. 50 тэрбум төгрөгөөр ихэсгэнэ
c. 100 тэрбум төгрөгөөр ихэсгэнэ
d. Дээрхийн аль нь зөв биш
36. Тухайн эдийн засгийн бүрэн ажил эрхлэлттэй үеийн үйлдвэрлэл 5000. Энэхүү хаалттай эдийн засгийн Засгийн газрын худалдан авалт 1000. Төлөвлөж буй хэрэглээ ба хөрөнгө оруулалтын функц нь дараах тэгшитгэлээр өгөгдсөн

$$C^d = 3000 - 2000r + 0.10Y$$


$$I^d = 1000 - 4000r$$
Y - орлого, r - бодит зээлийн хүү бол бүтээгдэхүүний зах зээлийг тэнцвэрт оруулах зээлийн хүүг ол.
a. 1.25%
b. 2.50%
c. 8.33%
d. 25.00%
37. I): Ажиллах хүчний насны бүтцийн өөрчлөлт ажилгүйдлийн хэвийн түвшинд нөлөөлдөг. II): Цалингийн доод түвшний өсөлт зэрэг институцийн өөрчлөлт мөчлөгийн ажилгүйдэлд нөлөөлдөг, харин хэвийн ажилгүйдэлд нөлөөлөхгүй.
a. I, II хоёулаа зөв
b. I зөв, II буруу
c. I буруу, II зөв
d. I, II хоёулаа буруу
38. Нэгэн улсын хүн ам 3 сая, ажилтай хүмүүсийн тоо 1.2 сая, ажилгүйчүүдийн тоо 0.3 сая байжээ. Ажиллах хүчний оролцоо 60% бол хөдөлмөрийн насанд хүрээгүй хүн амын тоо хэд вэ?
a. 2.5 сая
b. 0.5 сая
c. 1.5 сая
d. Аль нь ч биш
39. 38-р бодлогын нөхцөлд хөдөлмөр эрхлэлтийн түвшин аль нь вэ?
a. 40%
b. 48%
c. 50%
d. 80%
40. Хэрэв ДНБ-ий дефляторын суурь он 1996, ДНБ-ий дефляторын 2000 оны утга 107 бол, үнийн түвшин
a. 1996-гаас 2000 онд үнийн түвшин буурсан
b. 2000 онд 1996 онтой харьцуулахад 7 хувиар доогуур байсан
c. 2000 онд 1996 онтой харьцуулахад 7 хувиар өндөр байсан
d. 2000 онд 1996 онтой харьцуулахад 107 хувиар өндөр байсан

41. Засгийн газар төсвийн алдагдалыг бууруулах зорилгоор Засгийн газрын худалдан авалтыг бууруулсан бол....
- Үнийн түвшинг өсгөх нөлөө үзүүлнэ
 - Ажил эрхлэлтийг өсгөнө
 - Ажилгүйдлийг бууруулна
 - Дээрх бүх хариулт буруу
42. Бүрэн ажил эрхлэлтийн үе дэх их хэмжээний төсвийн алдагдлын өөрчлөлтийг зээлээр санхүүжүүлэх нь дараах байдлыг бий болгоно. Үүнд:
- Экспорт импортоос давах
 - Төгрөгний ханш чангарах
 - Бодит хүү буурах
 - Бодит хүү өсөх
43. Кипр улсын Засгийн газрын төсвийн алдагдал ирэх онд 200 тэрбум доллар байхаар байв. Хэрвээ тухайн улсын хүн ам нэмэлт нэгж орлогын 0.3-ыг хадгалах хандлагатай ба ЗГ ДНБ-ийхээ хэмжээг аль болох бага бууруулахыг хүсэж байгаа бол татварын орлогыг 30 тэрбум доллараар нэмэгдүүлэх, ЗГ-ын зардалыг 30 тэрбум доллараар бууруулахын аль хувилбарыг сонгон авах вэ?
- Татварын орлогыг нэмэгдүүлэх
 - ЗГ-ын зардалыг бууруулах
 - Тодорхойлох боломжгүй
44. Нэгэн хаалттай эдийн засаг бүхий улсын хувьд хөрөнгө оруулалт 100 тэрбум ба хэрэглээ $C=100+0.5 Y_D$, татварын орлого $T=20+t Y$ функцүүдээр тус тус илэрхийлэгддэг. Орлого нэг нэгжээр нэмэгдэхэд татварын орлого 0.2 нэгжээр нэмэгдэх хандлагатай бол ЗГ-ын зардал 10 тэрбумаар нэмэгддэг бол тэнцвэрт үйлдвэрлэл хэрхэн өөрчлөгдөх вэ ?
- 16.6
 - 32.6
 - 100.6
 - 120.6
45. Дараах зурагт дүрсэлсэн эдийн засгийн хувьд хөдөлмөрийн зах зээл болон үйлдвэрлэлийн тухай зөв мэдээллийг сонгоно уу.




- Эдийн засаг хямралтай, ажил эрхлэлтийн түвшин хэвийн түвшингээсээ өндөр байна.
- Эдийн засаг потенциал үйлдвэрлэлтэй, хэвийн ажилгүйдлийн түвшиндээ байна.
- Эдийн засаг потенциалаасаа их үйлдвэрлэлтэй, хэвийнээсээ бага ажилгүйдлийн түвшинтэй байна.
- Эдийн засаг хэт өсөлттэй, мөчлөгийн ажилгүйдэлтэй байна.


46. Дараах 3 зурагт дүрсэлсэн эдийн засгийн тэнцвэрүүдийн тухай мэдээллээс зөвийг нь сонгоно уу.



(a)



(b)



(c)

- Зураг (a)-д дүрсэлсэн эдийн засаг нь потенциалаасаа бага үйлдвэрлэлтэй, мөчлөгийн ажилгүйдэлтэй байна.
 - Зураг (b)-д дүрсэлсэн эдийн засаг нь потенциал үйлдвэрлэлтэй, хэвийнээсээ их ажилгүйдлийн түвшинтэй байна.
 - Зураг (c)-д дүрсэлсэн эдийн засаг нь хэт халалттай, мөчлөгийн ажилгүйдэлтэй байна.
 - Дээрх хариултуудын аль нь ч зөв тайлбар биш.
47. Эдийн засаг урт хугацааны тэнцвэртээ байсан бөгөөд бусад бүх хүчин зүйлс тогтмол үед үндэсний мөнгөн дэвсгэртийн ханш чангарснаар тухайн улсын эдийн засагт юу болох вэ?
- Үнийн түвшин буурна, үйлдвэрлэл өснө, ажилгүйдэл буурна.
 - Үнийн түвшин буурна, үйлдвэрлэл буурна, ажилгүйдэл нэмэгдэнэ
 - Үнийн түвшин нэмэгдэнэ, үйлдвэрлэл буурна, ажилгүйдэл нэмэгдэнэ
 - Үнийн түвшин нэмэгдэнэ, үйлдвэрлэл өснө, ажилгүйдэл буурна
48. Хөдөлмөрийн зах зээл нь зохицуулалт ихтэй эдийн засагт цалин уян хатан бус байдаг гэвэл ийм эдийн засаг зохицуулалт багатай эдийн засагтай харьцуулахад хямралаасаа
- Урт хугацааны нийт нийлүүлэлтийн муруйн зүүн талд нөөцийн үнэ хурдан буурдаг учраас хурдан гарна
 - Урт хугацааны нийт нийлүүлэлтийн муруйн зүүн талд нөөцийн үнэ удаан буурдаг учраас удаан гарна
 - Урт хугацааны нийт нийлүүлэлтийн муруйн баруун талд нөөцийн үнэ хурдан өсдөг учраас хурдан гарна
 - Урт хугацааны нийт нийлүүлэлтийн муруйн баруун талд нөөцийн үнэ хурдан өсдөг учраас удаан гарна
49. Урт хугацааны тэнцвэртээ байсан эдийн засагт бусад хүчин зүйлс тогтмол үед хүлээгдэж буй инфляцийн түвшин өсөх нь эдийн засагт дараах зүйлс ажиглагдаж болно.
- Үнийн түвшин өснө, ажилгүйдэл хэвэндээ
 - Үнийн түвшин буурна, ажилгүйдэл буурна
 - Үнийн түвшин буурна, ажилгүйдэл өснө
 - Тохирох хариулт нь байхгүй байна
50. Төсвийн орлого нь 100 хувь татварын орлогоор бүрддэг эдийн засгийн хувьд анхны тэнцвэрт үйлдвэрлэл 600 тэрбум, хөрөнгө оруулалт 50 тэрбум, хэрэглээ $C=60+0.5 Y_D$, татварын орлого $T=0.1 Y$, төсвийн алдагдал нь 0 байв. Энэ үед Засгийн газрын зардал 10 тэрбумаар нэмэгдсэн бол төсвийн алдагдал хэд болсон бэ?
- 15.59
 - 7.39
 - 10.59
 - 8.19